

MGL
Forex
Let's Trade, Let's Pro

МЕТА TRADER 4 ГАРЫН АВЛАГА

www.mglforex.mn

account@mglforex.mn

Утас: 7017-7170

Хаяг: УБ хот, Чингэлтэй, 1-р хороо Экспресс тауэр, 1201

Агуулга

МЕТATRADEP 4 ПЛАТФОРМЫГ ТАТАЖ СУУЛГАХ	3
МЕТATRADEP 4 ПЛАТФОРМ ДЭЭP ДЕМО ДАНС НЭЭХ	4
МЕТATRADEP 4 ПЛАТФОРМД НЭВТРЭХ	5
МGLFOREX ПЛАТФОРМЫН ХЭЛ СОНГОХ	6
АРИЛЖААНЫ ДАНСНЫ НУУЦ ҮГ СОЛИХ	7
НУУЦ ҮГЭЭ СЭРГЭЭХ	7
МЕТATRADEP 4 ПЛАТФОРМ ДЭЭРХ АРИЛЖААНЫ ТОХИРГОО	8
ХОСЛОЛ НЭМЭХ, ХАСАХ	9
АРИЛЖАА ХИЙХ/ ШИНЭЭР АРИЛЖАА НЭЭХ	11
ПОЗИЦ ХААХ /АРИЛЖАА ХААХ	13
MT4 ПЛАТФОРМЫН ГРАФИК АШИГЛАХ	16
СНАРТ –ИЙН ХЭЛБЭР	17
СНАРТ ФУНКЦУУД	18

МЕТАТРАДЕР 4 ПЛАТФОРМЫГ ТАТАЖ СУУЛГАХ


Алхам 1: MetaTrader 4 платформыг линкээс татаж суулгана. (https://mglforex.mn/?page_id=2175)

Алхам 2: Mglforex4setup.exe файлыг суулгана.

Алхам 3: Доорх зурагт үзүүлснээр next товчийг дарж үргэлжлүүлнэ.




Алхам 4: Доорх зурагт үзүүлснээр Finish товчийг дарснаар программ сууж дуусна.




МЕТАТРАДЕР 4 ПЛАТФОРМ ДЭЭР DEMO ДАНС НЭЭХ

Демо данс нээх 1: Хэрэв та демо данс нээлгэх бол зурагт үзүүлсэн MGLFOREX-demo Server-ийг сонгож Next товчийг дарна.



Демо данс нээх 2: Дараах зурагт үзүүлсэн New demo account хэсгийг сонгоод next товчийг дарна.



Демо данс нээх 3: Уг цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж Next товч дарснаар таны demo данс нээгдэнэ.

Open an Account

Personal details
To open an account, please fill out all the following fields:

Name: tanii ner
E-Mail: tanii_email_@yahoo.com
Phone: +976 99119911
Account type: MGLUSD
Deposit: 50000 USD
Leverage: 1:200
 I agree to subscribe to your newsletters

< Back Next > Cancel

МЕТАТРАДЕР 4 ПЛАТФОРМД НЭВТРЭХ

MetaTrader 4 платформд нэвтрэхдээ таны компьютерын дэлгэц дээр суусан “MGLFOREX FINANCIAL” icon дээр дарснаар нэвтрэх болно.



LIVE ДАНС нэвтрэх: Хэрэв та LIVE ДАНС (бодит арилжааны данс) нээлгэх бол **MGLFOREX**- оос и-мэйлээр илгээсэн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан дараах зурагт үзүүлсний дагуу нэвтрэх болно.

MGL FOREX FINANCIAL

Authorization allows to get access to the trade account

Login: 2088945099
Password:
Server: MGLFOREX-Live 7
 Save account information

Login Cancel

MGLFOREX ПЛАТФОРМЫН ХЭЛ СОНГОХ

Хэрэв та **MGLFOREX** платформын хэлийг солихыг хүсвэл View > Languages хэсгээс сонгох бөгөөд үүнээс Mongolian-ыг сонгож программыг restart хийснээр таны платформын хэл доорх зурагт харуулсантай ижил Монгол хэлтэй болохболно.


The screenshot displays the MQL5 IDE interface for the MGLFOREX platform. The 'View' menu is open, and the 'Languages' option is selected, showing a list of languages. 'Mongolian' is highlighted in blue. Other visible elements include:

- Market Watch Table:**

Тэмдэгт	Авах	Зарах
USDCHF	1.00445	1.0044
GBPUSD	1.23255	1.2326
EURUSD	1.06800	1.0680
USDJPY	113.341	113.34
USDCAD	1.30721	1.3072
AUDUSD	0.75445	0.7544
EURGBP	0.86649	0.8665
EURAUD	1.41554	1.4156
EURCHF	1.07276	1.0728
EURJPY	121.051	121.05
GBPCHF	1.23799	1.2381
CADJPY	86.699	86.70
GBPJPY	139.697	139.70
AUDNZD	1.04872	1.0488
AUDCAD	0.98624	0.9862
AUDCHF	0.75778	0.7578
- Navigator:** Shows account structure including 'MGLFOREX-Live 7' and '2088945099'.
- Chart Area:** Displays a candlestick chart for EURUSD, H4 timeframe, with a red trend line.
- Terminal:** Shows account balance: 'Баланс: 0.00 USD Хөрөнгө: 0.00 Сул маржин: 0.00'.

АРИЛЖААНЫ ДАНСНЫ НУУЦ ҮГ СОЛИХ

Та арилжааны аюулгүй байдлаа хангах үүднээс нууц үгээ сольж байх шаардлагатай. Иймд Tools > Options гэж ороод change товч дээр дарснаар 2 дахь цонх нээгдэх бөгөөд нууц үгээ солих боломжтой болно.



НУУЦ ҮГЭЭ СЭРГЭЭХ


Хэрэв та нууц үгээ мартсан бол манай дансны ажилтан руу 976-70177170 утсаар холбогдох, эсвэл account@mglforex.mn хаяг руу өөрийн и-мэйл хаягаас захиа бичиж өөрчлөх боломжтой.

МЕТАТРАДЕР 4 ПЛАТФОРМ ДЭЭРХ АРИЛЖААНЫ ТОХИРГОО

Арилжааны хэрэглүүрүүд сонгох:

Market Watch Window (Instruments Window)

Market Watch Window нь арилжааны ханшийн самбарыг харуулах, үгүйг сонгох юм. Уг самбарыг харуулахын тулд CTRL+M эсвэл View цэснээс Market Watch хэсгийг сонгоно.




Уг цэсийг сонгосноор доорх зурагт үзүүлсэнтэй ижил зүүн талд ханшийн самбар харагдана.





ХОСЛОЛ НЭМЭХ, ХАСАХ

Хэрэв та өөрийн арилждаг валют, метал, индекс, нефтийн бүтээгдэхүүн зэрэг байнга харахыг хүссэн хослолоо Market Watch хэсэгт хулганы баруун товч дарснаар доорх зурагт үзүүлсэн цэс гарна. Үүнээс Symbols –руу орж өөрийн харах хослолуудыг сонгох боломжтой. Эсвэл VIEW цэснээс symbols, гарын драйвар ашиглан CTRL+U дарж Symbols цонхыг дуудаж болно.



Уг Symbols цонхруу ороход доорх зурганд үзүүлсэнтэй ижил арилжааны хэрэглүүрүүд гарч ирэх бөгөөд үүнээс та өөрийн үргэлж ашиглах хослолуудыг сонгож SHOW товчин дээр дарж идэвхижүүлсэнээр Market Watch хэсэгт таны хослолууд харагдах болно. Хэрэв та хасах бол HIDE товчин дээр дарснаар Market Watch хэсгээс хасагдана.



Шараар тэмдэглэсэн хэсэг нь таны Market Watch самбарт харагдаж байгаа ба саарал өнгөтэй байвал самбарт харагдахгүй байгааг харуулна.

АРИЛЖАА ХИЙХ/ ШИНЭЭР АРИЛЖАА НЭЭХ

Та арилжаа хийх хослол дээрээ давхар товшиход шинэ арилжаа нээх цонх гарч ирнэ.

Symbol	Bid	Ask
USDCHF	1.00167	1.00173
GBPUSD	1.23313	1.23321
EURUSD	1.06964	1.06969
USDJPY	113.125	113.131
USDCAD	1.30542	1.30542
AUDUSD	0.75575	0.75575
EURGBP	0.86731	0.86739
EURAUD	1.41533	1.41547
EURCHF	1.07145	1.07151
EURJPY	121.004	121.009
GBPCHF	1.23522	1.23540
CADJPY	86.660	86.668
GBPJPY	139.504	139.515
AUDNZD	1.04919	1.04937
AUDCAD	0.98644	0.98656
AUDCHF	0.75695	0.75707
AUDJPY	85.489	85.497
CHFJPY	112.930	112.942
EURNZD	1.48502	1.48527
EURCAD	1.39621	1.39632
CADCHF	0.76730	0.76741
NZDJPY	81.475	81.487
NZDUSD	0.72020	0.72026
OILUSD	53.57	53.61
XAUUSD	1213.66	1213.79
XAGUSD	17.15	17.16

Euro vs US Dollar
Calculation: Forex
Trade: Full

Давхар товшсоны дараа дараах цонх нээгдэнэ.

Order
EURUSD

Symbol: EURUSD, Euro vs US Dollar

Volume: 1.00

Stop Loss: 0.00000 Take Profit: 0.00000

Comment:

Type: Market Execution

Market Execution

1.06935 / 1.06940

Attention! The trade will be executed at market conditions, difference with requested price may be significant!

Доорх цонхонд дараах мэдээллүүд байна:

Symbol: Энэ хэсгээс арилжаа хийхийг хүссэн хослол болон арилжаа хийх гэж буй хослол харагдана.

Volume: Арилжааны хэмжээ байх бөгөөд хэрэв **EUR/USD** хослолыг сонгосон бол 1 lot size нь 100,000 EUR-г ам.долларын эсрэг авах/зарах захиалга өгөх гэж байна. Хэрэв 0.01 lot сонгосон бол (1,000) EUR-г ам.долларын эсрэг авах/зарах захиалга өгнө гэсэн үг юм. (1 lot = 100,000)

Stop-Loss: Алдагдал зогсоох хязгаар буюу ханш эсрэг зүгт хөдлөөд нэг ханшинд хүрэхэд арилжаагаа зогсоох захиалга.


Take Profit: Ханш тодорхой нэг цэгт хүрэхэд ашигаа аваад позицоо хаах захиалга.

Comment: Хэрэв хийсэн арилжаандаа сануулга болон тэмдэглэл хөтлөх бол бичиж бөглөнө.

Type: Энэ хэсэгт 2 сонголттой:

1. Instant Trade – Одоо биелэхарилжаа
2. Pending Order – Дараа биелэхзахиалга

Ханш тодорхой түвшинд хүрэхэд авах/зарах захиалга өгөх, эсвэл ямар хугацаанд гэдгээр нь зааж өгнө.



Хэрэв та арилжааны дүн хослолоо сонгоод арилжаа хийсэн бол дээрх цонх харагдана.


ПОЗИЦ ХААХ /АРИЛЖАА ХААХ

Trade Terminal цонхонд таны хийсэн арилжааны мэдээлэл гарна.

Order /	Time	Type	Size	Symbol	Price	S / L	T / P	Price	Commission	Swap
2101368446	2017.01.18 08:51:59	sell	1.00	eurusd	1.06926	0.00000	0.00000	1.06921	0.00	0.00

Balance: 50 000.00 USD Equity: 50 005.00 Margin: 534.63 Free margin: 49 470.37 Margin level: 9353.20%

Та позицоо хаахдаа дээрх зурагт үзүүлсэн хаах гэж буй арилжаан дээр давхар товшилт хийнэ. Тэгснээр доорх цонх гарах бөгөөд Close товч дээр дарснаар таны позиц хаагдана.



Позицоо хэсэгчилж хаах:

Та нээлттэй байгаа позицоо хэсэгчилж хааж болох ба ингэхийн тулд позиц дээрээ давхар товшилт хийж Volume хэсэг дээр хаах дүнгээ оруулж Close товч дээр дарснаар хэсэгчилж хааж болно. Жишээ нь та 1 lot EUR/USD позицтой байгаад 0.6 lot позицоо хаахыг хүсвэл volume дээр нь 0.6 гээд Close товч дээр дарахад таны позицоос 0.6 Lot нь хаагдаж 0.4 lot позиц нь хэвээр үлдэнэ.


Нээлттэй позицийнхоо захиалгыг өөрчлөх:

Хэрэв та нээлттэй позицынхоо stop loss болон take profit –ыг өөрчлөх бол нээлттэй позиц дээрээ давхар товшилт хийж гарч ирсэн цонхны TYPE хэсгээс Modify Order-ыг сонгоно.

Order /	Time	Type	Size	Symbol
6614995	2012.08.23 12:00	buy	0.01	eurusd
6615012	2012.08.23 12:00	buy	0.01	audusd
6615019	2012.08.23 12:00	sell	0.01	gbpusd
6615022	2012.08.23 12:00	sell	0.01	usdjpy

Trade Account History Alerts Mailbox Experts Journal


Navigator page



Дээрх зурагт үзүүлснээр Stop loss болон Take profit –ын захиалгыг өгөх боломжтой.

Биелэгдээгүй захиалга буюу Pending order нь ирээдүйд үнэ ханш нь хэрхэн өөрчлөгдөхөөс шалтгаалсан захиалгыг хэлнэ.

MGLFOREX MT4 платформ нь 4 өөр төрлийн захиалгын төрөлтэй:



Buy Limit:

Ханш одоогийн ханшаас унаад тодорхой нэг цэгт хүрэхэд худалдаж авах захиалга юм. Энэ захиалга нь одоогийн ханшаас доош орсон үед өгөх захиалга.

Sell Limit:

Ханш одоогийн ханшаас өсөөд тодорхой нэг цэгт хүрэхэд худалдах захиалга юм. Энэ захиалга нь одоогийн ханшаас дээш орсон үед өгөх захиалга.


Buy Stop:

Ханш одоогийн байгаа ханшаас өсөөд тодорхой цэгт хүрэхэд худалдаж авах захиалга юм.

Sell Stop:

Ханш одоогийн байгаа ханшаас өсөөд тодорхой цэгт хүрэхэд худалдаж авах захиалга юм.

Дээрх захиалгын төрлүүдийг доорх зурагт дэлгэрэнгүй тайлбарлав:



Биелэгдээгүй захиалгуудыг өгөхийн тулд арилжаа хийх хослолоо сонгоод TYPE хэсгээс pending Order хэсгийг сонгоно. Pending Order хэсгийн Type хэсгээс захиалгынхаа төрлийг сонгоод PLACE товч дээр дарснаар таны захиалга идэвхижих болно. Мөн Expiry хэсэгт тухайн захиалга нь хэдий хүртэлх хугацаанд идэвхитэй байхыг сонгож болно.

The screenshot shows a "Pending Order" window for the USDJPY pair. The window title is "Order #6615022 sell 0.01 USDJPY at 78.646 sl: 0.000 tp: 0.000".

On the left, a small chart shows the current price at 78.552. The price scale ranges from 78.519 to 78.552.

On the right, the order details are as follows:

- Symbol: USDJPY, US Dollar vs Japanese Yen
- Volume: 0.01
- Stop Loss: 0.000
- Take Profit: 0.000
- Comment: (empty)
- Type: Pending Order
- Pending Order Type: Buy Limit (selected in the dropdown menu)
- at price: (empty)
- Expiry: 8/20/2012 13:55
- Place button

A note at the bottom states: "Open price you set must differ from market price by at least 80 pips."

MT4 ПЛАТФОРМЫН ГРАФИК АШИГЛАХ

Market Watch самбараас өөрийн харахыг хүссэн хослол дээр баруун товч дээрээ дарснаар доорх цонх гарч ирнэ. Энэ хэсгээс Chart Window гэдгийг сонгосноор шинэ Chart цонх үүснэ.





CHART –ИЙН ХЭЛБЭР

MetaTrader 4 дараах 3 төрлийн графикын сонголттой:

- LineChart
- BarChart
- CandlestickChart

Line Chart

Энэхүү чарт нь үндсэн чарт юм. Ханшийн хөдөлгөөнийг шугамаар харуулна.



Bar Chart

Уг чарт нь нээлт, хаалтын ханшийг таны тохируулсан хугацаагаар харуулдаг түгээмэл хэрэглэгддэг чартын төрөл юм:




Candlestick Chart

Тус график нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг, уг лааны дүрслэл дээр техник шинжилгээ хийж болдог зэргээрээ давуу талтай. Ямар ч хугацааны үечлэлд тохируулсан хугацааны нээлт, хаалт, дээд, доод ханшийг илэрхийлж чаддагаараа давууталтай.



CHART ФУНКЦУУД

Дараах зурагт үзүүлснээр функцуудын товчнуудыг байнга ашиглахаар тохируулж болно.



Хугацааны хэрэгсэл



Дараах төрлүүдээс сонгоно.

<u>1</u>	1 Minute Chart	<u>M30</u>	30 Minute Chart	<u>D1</u>	Daily Chart
<u>5</u>	5 Minute Chart	<u>H1</u>	1 Hour Chart	<u>W1</u>	Weekly Chart
<u>15</u>	15 Minute Chart	<u>H4</u>	4 Hour Chart	<u>MN</u>	Monthly Chart

CHART TOOLBAR



1. Доорхоос сонгож дарна:

A.Bar Chart



Б.CandlestickChart



В.LineChart



2. + - товчин дээр дарж сонгосон чарт аа томруулах, жижигрүүлэх боломжтой

3. Мөн техник шинжилгээний загваруудаас сонгож оруулах боломжтой.

